



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/57

Бат-Өлзий сум

Сэг, зэм устгал, ариутгал, халдваргүйтгэлийн
ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12 дахь заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг эрчимжүүлэх, мал, амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, сэг зэм устгах тухай” 01 дүгээр албан даалгавар, Өвөрхангай аймгийн Засаг даргын “Бог малын гоц халдварт, цэцэг өвчинтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” 2024 оны 03 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн үйл ажиллагааг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 05 дугаар сарын 10-ны хооронд шуурхай зохион байгуулсугай.

2. Мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг зохион байгуулах, отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнд хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлыг төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Мал, амьтны сэг, зэмийг цуглуулж, орчны цэвэрлэгээ хийхэд малчид иргэдийг оролцуулж ажиллахыг бүх багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Орон нутгийн чанартай зам дагуух болон цуглуулсан мал, амьтны сэг зэмийг булж устгахыг Бат-Өлзий тохижилт үйлчилгээ улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал (А.Долгор-Өлзий)-д үүрэг болгосугай.

5. Мал эмнэлгийн халдваргүйтгэлийн ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг мал эмнэлэг, үйлчилгээний нэгжийн их эмч (Л.Батчулуун), (П.Содномбалжир) нарт тус тус үүрэг болгосугай.

6. Мал, амьтны сэг, зэмийг цуглуулж, булж устгах ажлын гүйцэтгэл чанарт хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Б.Янжиндулам), Мал эмнэлгийн улсын байцаагч (П.Аюушжав) нарт тус тус даалгасугай.


7. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Орхонтуул), уг ажилд шаардагдах зардлын тооцоог гарнахыг нягтлан бодогч (Ч.Батдулам) нарт даалгасугай.

ДАРГА С.АМГАЛАН

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

20240408

Бат-Өлзий сумын Засаг даргын 2024 оны
04 дүгээр сарын 08-ны өдрийн 1157
дугаар захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)

Гишүүд:

- С.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)
 - Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)
 - С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)
 - Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)
 - Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)
 - Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)
 - Б.Янжиндулам (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)
 - Д.Очирхуяг (Ойн ангийн дарга)
 - Ш.Бумандолгор/ Ойн ангийн инженер/
 - А.Мягмардагва/ Ойн ангийн инжежер/
 - Ц.Амгалан / Ойн ангийн техникч/
 - Ж.Батмөнх (Байгаль хамгаалагч)
 - Б.Энхмаа (Байгаль хамгаалагч)
 - Т.Жамъянжав (Гэрээт ажилтан)
 - Б.Амарцэцэг (Гэрээт ажилтан)
 - Н.Түвшин (Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан
мэргэжилтэн)
 - Э.Буянтогтох (Мал, аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн)
 - Л.Батчулуун ("Хустын-Рашаан" мал эмнэлэг, үйлчилгээний нэгжийн
эмч)
 - П.Содномбалжир ("Хутагт уулын өгөөж" мал эмнэлэг, үйлчилгээний
нэгжийн эмч)
 - А.Долгор-Өлзий (Бат-Өлзий тохижилт үйлчилгээ улсын төсөвт
үйлдвэрийн газрын захирал)
- Нарийн бичгийн дарга: П.Аюушжав (Мал эмнэлгийн тасгийн дарга)

Бат-Өлзий сумын Засаг даргын 2024 оны
0.4 дүгээр сарын 08 өдрийн 457 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

МАЛ, АМЬТНЫ СЭГ ЗЭМИЙГ ЦУГЛУУЛЖ УСТГАХ, ОРЧНЫ ЦЭВЭРЛЭГЭЭ
ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙГ САРЫН АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН
ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Ажил үйлчилгээ	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран хэрэгжүүлэгч
1	2	3	4	
1. Удирдлага зохион байгуулалт				
1.1	Хорогдсон малын сэг зэмийг устгах, халдваргүйжүүлэх ажлын Засаг даргын захирамж гаргаж, төлөвлөгөө боловсруулж бүх нийтийн ажил болгон зохион байгуулах	4 дүгээр сарын 10-ны дотор	Багийн Засаг дарга нар	Байгаль орчны хчналтын улсын байцаагч, Мал эмнэлгийн улсын байцаагч
1.2	Орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэл хийх мэргэжил арга зүй, зөвлөмж, удирдлагаар хангах, хяналт тавих	Тогтмол	Засаг даргын Тамгын газар	Мал эмнэлэг үйлчилгээний нэгжүүд, Малчид
1.3	Эзэнгүй орхисон мал, амьтны хүүр, сэг зэмийн эх үүсвэрийг мөрдөн мөшгөж тогтоон, буруутай этгээдэд холбогдох хууль, журмын дагуу хариуцлага тооцох, үр дүнг тайлагнах	Тухай бүр	Багийн Засаг дарга нар	Малчид, иргэд
1.4	Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах	Улиралд 1 удаа	Бат-Өлзий тохижилт үйлчилгээ улсын төсөвт үйлдвэрийн газар	Байгаль хамгаалагч
1.5	Хийж гүйцэтгэсэн ажлын тайланг заасан хугацаанд гаргаж ирүүлэх, нэгтгэж үр дүнг тооцон Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах	5 дугаар сарын 10-ны дотор	Б.Янжиндулам	Засаг даргын Тамгын газар
2. Мал эмнэлгийн тасаг, Хөдөө аж ахуйн тасаг				
2.1	Отор нүүдэл шилжилт хөдөлгөөнд хяналт тавин ажиллах	Тогтмол	П.Аюушжав Э.Буянтогтох	Мал эмнэлэг, үйлчилгээний нэгжүүд, Малчид
2.2	Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчний дуудлага, үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллах	Тухай бүр	П.Аюушжав	Мал эмнэлэг, үйлчилгээний нэгжүүд
2.3	Малын гоц халдварт, халдварт, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулах	Жилдээ	П.Аюушжав	Мал эмнэлэг, үйлчилгээний нэгжүүд, Малчид
2.4	2024 оны халдваргүйтгэлийн төлөвлөлтийг мал эмнэлгийн нэгдсэн системд оруулах	4 дүгээр сарын 10-ны дотор	П.Аюушжав	Мал эмнэлэг, үйлчилгээний нэгжүүд

2.5	Халдваргүйтгэлийн бодисын нөөц, хэрэглээ, чанар үр дүнд хяналт тавих	Тухай бүр	П.Аюушжав	Мал эмнэлэг, үйлчилгээний нэгжүүд
2.6	Хээлтүүлэгч малын суурьт гоц халдварт, халдварт өвчний эмнэлзүйн үзлэг хийх, шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээнд хамруулж баталгаа гаргах	Хагас жилдээ	П.Аюушжав Э.Буянтогтох	Мал эмнэлэг, үйлчилгээний нэгжүүд, Малчид
2.7	Хорогдсон малын сэг зэмийг булж устгах устгалын цэгийн судалгааг гаргах	4 дүгээр сарын 02-ны өдрийн дотор	Ажлын хэсэг	Багийн Засаг дарга нар
2.8	Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах, цуглуулах үйлдвэр, түүхий эд бүтээгдэхүүний төвүүдтэй халдваргүйтгэл хийх гэрээ байгуулан ажиллах	Жилдээ	Мал эмнэлгийн тасаг	Мал эмнэлэг, үйлчилгээний нэгжүүд, Түүхий эдийн төвүүд
2.9	Цугларсан сэг зэмийг тогтоосон цэгт булж устгах	5 дугаар сарын 05-ны дотор	Засаг даргын Тамгын газар	Малчид, Туслах ажилчид
3.Сургалт, мэдээ, мэдээлэл зөвлөмж хүргүүлэх				
3.1	Хуулийн хүрээнд мал, амьтан өмчлөгч этгээдийн үүрэг, хариуцлагыг тодорхойлсон зөвлөмж гарган хүргүүлэх	4 дүгээр сарын 20-ны дотор	Ажлын хэсэг	Мал эмнэлгийн тасаг
3.2	Малчдыг мэдээ мэдээллээр хангаж, гарын авлага, шторк, сургалтын ажлыг үе шаттай зохион байгуулах	Тогтмол	Мал эмнэлгийн тасаг, Хөдөө аж ахуйн тасаг	Засаг даргын Тамгын газар
4.Өдөр тутмын мэдээ, мэдээлэл солилцох				
4.1	Орон нутгийн чанартай авто зам дагуух сэг зэмийг цуглуулж устгасан мэдээг мэдээллэх	7 хоног бүрийн 3 дахь өдөр	Б.Янжиндулам	Багийн Засаг дарга нар
4.2	Малын зүй бус хорогдол, сэг зэм устгал, халдваргүйтгэлийн явцын мэдээг загвар хүснэгтийн дагуу ирүүлэх	Тухай бүр	П.Аюушжав	Багийн Засаг дарга нар, Хөдөө аж ахуйн тасаг